

БАТЛАВ.

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА

Я.БОЛДБААТАР/
2017 оны 5 дугаар сарын 15

БАТЛАВ.

"МОНГОЛ МАЙНИНГ ЭНД ЭКСПЛОРАЙШН"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.БАТБОЛД/
2017 оны 5 дугаар сарын 15

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 12

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүгнэлт хүргүүлэх тухай" 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 80 тоот, Туул голын сав газрын захиргааны даргын 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А-26 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Ус ашиглалтыг зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлөөлж тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, "ТГ" төв, 3-302 тоотод байрлах улсын бүртгэлийн 9011165058 тоот гэрчилгээ, 5253535 тоот регистрийн дугаартай "Монгол майнинг энд эксплорайшн" ХХК-ийн захирал Г.Батболд нар ус ашиглах талаар тохиролцож, 2017 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Төв аймгийн Заамар сумын нутаг орших MV-5028 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Ар Наймганы дунд хэсгийн алтны шороон орд"-ын үйлдвэрлэлийн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 15'000 м³ элс угаахад 60'000 м³/жил ус

2.2.1. Унд, ахуйд: 534 м³/жил

2.2.2. Үйлдвэрлэлийн хэрэгцээнд: 22'435 м³

2.2.3. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжинд: 2000 м³

2.2.4. Зам, талбайн тоосжилт дарахад: 1200 м³

2.2.5. Шавхан зайлуулах усны хэмжээ: 23'126 м³

2.3. Усны чанар, найрлага: Гүний худгаас болон хаягдлын нуураас усны дээж авч шинжлүүлэн ус ашиглалтын тайланд хавсаргана.

2.4. Усны эх үүсвэр:

2.4.1. Байршил: Унд-ахуйн усны хэрэгцээг кэмпээс урагш байрлах 73 м гүнтэй, 7.2 л/сек ундаргатай гүний худгаас, технологийн хэрэгцээний усыг газрын доорх усны шүүрэлтийн усаар бий болсон хиймэл нуураас нөхөн сэлбэлтээр тус тус авч ашиглана.

Худгийн байршил: 104° 19'58.11", 48° 20'14.2"

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2.4.2. *Барилга байгууламж*: Хуучин ашиглаж байсан нуурын эзлэхүүн 292'000 м³. Олборлолт /50-60 м гүн/-ын явцад үүсэх шүүрэлтийн усыг 219 мм диаметртэй 150 м урт ган хоолойгоор дамжуулан шахаж 20000 м³ эзлэхүүнтэй усан санд өөрийн урсгал /500 м/-аар хүргэнэ. Харин усан сангаас угаах төхөөрөмж рүү 219 мм диаметртэй, 210 м урттай ган хоолойгоор ус татна.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк*: ТК-100 маркийн угаах төхөөрөмжтэй.

2.4.4. *Насосны хүчин чадал*: Гүний худагт ЭЦВ6-10-80 маркийн насос, олборлолтын явцад үүсэх шүүрэлтийн усыг Д-1250 маркийн насосоор усан сан руу, усан сангаас угаах төхөөрөмжийн шугамд Д-100/80 маркийн насосууд суурилуулсан.

2.5. *Хаягдал усны хэмжээ*:

2.5.1. *Стандартын шаардлага*: Үйлдвэрлэлээс гарах технологийн хаягдал болон ахуйн бохир усыг цэвэршүүлэн хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ Хаягдал усны стандарт (MNS-4943:2011)-ын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.5.2. *Хаях цэгийн байршил*: Ахуйн бохир усыг уурхайн тосгон /104° 30' 36", 48° 16' 57.6"/-ны хашаанд байрлах бохирын цооногт хуримтлуулан хөрсөнд шингээн зайлуулдаг. Технологийн хэрэгцээнд ашигласан усыг тунгаагуурт тунгааж, эргүүлэн ашиглана.

2.6. *Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ*:

2.7. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин*: Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана.

2.8. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ*:

2.9. *Усны тоолуур*: Усны тоолууртай.

2.10. *Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ*:

2.10.1. Үйлдвэрлэлийн хэрэгцээнд шүүрэлтийн уснаас тогтсон нуураас болон шавхан зайлуулах 25'635 м³ усны төлбөрт 25'409'413 төгрөгийг Төв аймгийн Төрийн сан банкны 140000944 тоот дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 10 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцөлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

Ус ашиглалтыг зохицуулах албаны
дарга

 /Ю.Сувдчимэг/

"Монгол майнинг энд эксплорэйшн"
ХХК-ийн төлөвлөлтийн инженер



Мэдээлэл, хяналт үнэлгээний албаны
дарга

/Б.Оюунболд/

/Б.Баярбаатар/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул
уурхай, эрчим хүчний ус ашиглалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /С.Сүхбат/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүргийн 1-р хороо, Энхтайваны өргөн
чөлөө, "ТГ" төв, 3-302 өрөө
Харилцах утас: 99025061, 88113110

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захиргааны
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 363716, 363714, 362592